



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 01/641

Улаанбаатар хот

**Нийслэлийн ерөнхий боловсролын “Амгалан”
цогцолбор сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 13,735,835.68 /арван гурван сая долоон зуун гучин таван мянга найман зуун гучин таван төгрөг жаран найман мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын “Амгалан” цогцолбор сургууль /Л.Баянтуул/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй номыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын “Амгалан” цогцолбор сургууль /Л.Баянтуул/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

1119282495 д. 2576589

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 02 дугаар
 сарын 04 өдрийн 0/007 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын "Амгалан" цогцолбор сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон жил	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Ном, сурах бичиг	2009-2016	3-10 жил	ш	8,002	13,735,835.68	13,735,835.68			Эрүүл ахуйн шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй.	устгах
Номын фондын дүн					8,002	13,735,835.68	13,735,835.68	-	-		
Нийт дүн							13,735,835.68				
Актлах хөрөнгө							13,735,835.68				
Татан төвлөрүүлэх хөрөнгө							0.00				